

БАТЛАВ:


САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА *Амгун* С. ХОНАЕВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2015 ОНЫ 03 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

/ Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх , тэмцэх арга хэмжээний тухай /  
2015.04.09

№	Хэрэгжүүлэх ажлын товч утга	Хугацаа	Хариуцах эзэн
1	Цаг агаарын мэдээ мэдээллийг тогтмол авч, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх , хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллах	Тогтмол	Онцгой комисс
	Гамшигт болон аюулт үзэгдлийн үед албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, үйл ажиллагаанд дайчлагдан ажиллах иргэдийн тоон судалгаа, автомашин, техник, багаж хэрэгслийн судалгааг гаргах, нөөц бүрдүүлэх, найдвартай ажиллагаагаар ханган ажиллах	Жилийн турш	ЗДТГ
2	Үер, усны юулд өртөж болзошгүй голын арал, тохой, томоохон голуудын эрэг дагуу, уулын усны буулт, жалга, судгийн аманд буусан айл эрхийн судалгааг гаргаж, аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах	5-р сард	Сумын онцгой комисс
3	Бага насны хүүхдийг хараа хяналтгүй гол, мөрний эргээр явуулахгүй байх талаар гэр бүл, асран хамгаалагчдад зөвлөх, иргэд болгоомжгүй байдлаас усанд осолдож, амь насаа алдахаас урьдчилан сэргийлж, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	4 дүгээр сард	Онцгой комисс ЗДТГазар
4	Үерийн хамгаалалтын далан, зам талбайн ус зайлуулах, зориулалтын байгууламжуудад үзлэг шалгалт хийж, үерийн далан, сувгийн цэвэрлэгээг тогтмол хийж, үерийн ус чөлөөтэй урсах нөхцөлийг бүрдүүлэх, албан байгууллага, шатахуун түгээх станцуудын аянга зайлуулагчийн ажиллагааг шалгах	4 дүгээр сард	Онцгой комисс ЗДТГ
5	Үерийн эрсдэл бүхий нутаг дэвсгэрт далан, ус зайлуулах суваг татах, шинээр баригдах авто зам, талбайн зураг төсөлд тусгах	Тухайн үед	ЗДТГ
6	Гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас зам, даваа хаагдаж , нөхцөл байдал хүндэрсэн үед тухайлсан чиглэлд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийх, арга хэмжээг шуурхай зохион байгуулах, зорчигч тээврийн үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих	Тухайн үед	Онцгой комисс
7	Хүчтэй салхи, шуурганы үеэр цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	Тухайн үед	Онцгой комисс
8	Албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцон аймгийн Онцгой комисс, ЗДТГ-т мэдээлж байх	6 ба 12-р сарын 20 ны дотор	Онцгой комисс

БОЛОВСРУУЛСАН: ЗДТГАЗАР



БАТЛАВ:

САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА *Доржпүрэв* С. ХОНАЕВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2015 ОНЫ 02 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

/ Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай /

2015.04.09

№	Хэрэгжүүлэх ажлын товч утга	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах сумын зөвлөл байгуулж, зөвлөлийн ажлыг зохицуулах дүрмийн сургалт явуулах, олшруулж тараах	4 дүгээр сард багтаан хэрэгжүүлэх	ЗДТГазар
2	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллах	Жилийн турш	ЗДТГ
3	Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд түүнийг унтраах үйл ажиллагаанд дайчлагдан ажиллах иргэдийн тоон судалгаа, автомашин, техник, багаж хэрэгслийн судалгааг гаргах, нөөц бүрдүүлэх, найдвартай ажиллагаагаар ханган ажиллах	4 дүгээр сард багтаан гаргах	Сумын онцгой комисс
4	ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллагаас хөдөлгөөнт болон морин эргүүлийг тогтмол зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг шаардлагатай эд материалаар хангах ажлыг зохион байгуулах	Тухайн үед	Онцгой комисс Сумын зөвлөл
5	Сумын хилийн зааг дээр гарсан түймрийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй унтраах, гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед хамтран ажиллах ажиллагааг шуурхай болгох	Тухайн үед	Онцгой комисс Сумын зөвлөл
6	Ой хээрийн гал түймрийн голомтод бие бүрэлдэхүүний байршил тодорхойлох /GPS/ холбооны хэрэгслээр бүрэн хангах, голомтын уртраг, өргөрөгийн солбилцолыг шуурхай тодорхойлох, дуудлага хүлээн авсан албан тушаалтан болон цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлж байх	Тухайн үед	Онцгой комисс Сумын зөвлөл
7	Түймэр гарсан тухай бүр Цагдаагийн байгууллагад мэдээлж, гарсан шалтгаан, нөхцөл, эзэн холбогдогчийг илрүүлж, тогтоох ажилд шаардлагатай мэдээ, мэдээлэл солилцон хамтран ажиллах	Тухайн үед	Онцгой комисс Сумын зөвлөл
8	Хуурайшилттай үед гал түймрээс сэргийлэх тухай радио, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон ИНХ-аар тогтмол сурталчлах, ой мод руу орох гол зам, гүүрэнд анхааруулгын тэмдэг тавих, самбар байрлуулах	Тогтмол	Онцгой комисс Сумын зөвлөл
9	Албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцон аймгийн Онцгой комисс, ЗДТГ-т мэдээлж байх	6 ба 12-р сарын 20 ны дотор	Онцгой комисс Сумын зөвлөл

БОЛОВСРУУЛСАН: ЗДТГАЗАР